



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/64

Арвайхээр

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.б, 29.2, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр батлах тухай” 98 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгдийн Хурлын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн “Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр батлах тухай” 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч – Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

- Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга

- Ус цаг уур, орчны шинжилгээний албаны дарга

- Арвайхээр сумын Засаг дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн газар, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

- Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

- Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ны захирал

- “Баянтээг” ХК-ний захирал

- “Баянтээг” ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

- Шахмал түлшний үйлдвэрийн захирал

- “Хангамж-Өргөө” ХХК-ний захирал (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга - Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин аялал жуулчлалын газрын Орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн

2. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсгийн ахлагч (.И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/257 дугаар захирамжийг хүчингүй болгосугай

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100144